



Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2010



"ГЛОБ ИНТЕРНЭШНЛ" ТББ



АНУ-ын Элчин Сайдын Яам



Нээлттэй Нийгэм Хүрээлэн



Нээлттэй Нийгэм Форум

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2010

Энэ тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн ивээн тэтгэгчдэдээ гүн талархал илэрхийлье.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага нь 1999 оны 3-р сард Улаанбаатар хотноо байгуулагдсан, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй, ашгийн төлөө бус байгууллага юм.

Эрхэм зорилго

Мэдээлэл, мэдлэгийн хүчийг түгээж, Монголд ардчилал, иргэний нийгмийг хөхиүлэн дэмжих

Алс хэтийн хараа

Ардчилсан соёл төлөвшсөн нийгэм, мэдээлэлтэй, чадавхитай иргэд

Үнэт зүйлс:

- Хараат бус
- Шударга ёс
- Ардчилсан
- Ялгаварлан гадуурхалтаас ангид
- Авлигагүй

Стратегийн зорилт, үндсэн хөтөлбөр

- Хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь
- Засаглал, ил тод байдлыг хөхиүлэн дэмжих нь
- Олон нийтийг чадавхжуулах нь



Мэдлэг бол - Хүч

Хаяг: Чингэлтэй дүүрэг, VI хороо,
Дипломат 95 цогцолбор, 6-р орц 70
тоот Улаанбаатар – 211238,
ш/х 102, Монгол улс

Утас: 976-11-324627,
976-11-324764

Факс: 976-11-315326

Э-шуудан: globenews@globeinter.org.mn,
hnanan@globeinter.org.mn,

Веб: www.globeinter.org.mn

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	4
НЭГ. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ 2010 ОНД	6
ХОЁР. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ	17

ӨМНӨТГӨЛ

Бид Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний тайлан бэлтгэж, та бүхэнд өргөн барьж буйдаа баяртай байна.

Энэ ялдамд тайланг бэлтгэх боломж олгосон Улаанбаатар дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөр, Нээлттэй Нийгэм Форумд талархал илэрхийлье.

Хэвлэлийн эрх чөлөөний тайлан нь Монголын сэтгүүлчид мэргэжлийн эрхээ хэрхэн эдэлж буй, тэдний олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа шударгаар биелүүлэх боломж нь аль хэр байгааг баримтад тулгуурлан монголын хэвлэлийн эрх чөлөөний өнөөгийн дүр төрхийг харуулах зорилготой юм.

2010 онд Монголын хэвлэл мэдээлэл, мэдээллийн эрх зүйн салбарт бодлого, зохицуулалтын олон баримт бичиг, дүрэм журам батлагдаж, хуулийн төсөл боловсруулснаараа онцлог боллоо. Орчин үеийн мэдээллийн шинэ технологийн хөгжил, уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн цахимжилт, шинэ хэвлэл мэдээллийн хурдацтай дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, ялангуяа өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн тоо нэмэгдэж буй зэрэг нь ийм хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

Монгол улсад 2010 оны 12-р сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй 418 хууль, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1287 хуулийн 188 -д нь мэдээллийн эрх чөлөө, төрийн байгууллагын ил тод байдал, үзэл бодлоо

илэрхийлэх эрх, эрх чөлөө, хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулсан зүйл, заалт оржээ. 2001 онд “19-р зүйл” олон улсын байгууллагатай хамтран хийсэн судалгаагаар тухайн үед үйлчилж байсан 91 хуульд дээрх зохицуулалт тусгагдсан байсан юм.

Монгол улсын Засгийн газраас 2011 оны нэгдүгээр сарын 21-ний өдөр “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа. УИХ-ын чуулганы 2011 оны дөрөвдүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар гишүүдийн 86.6 хувийн саналаар хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэжээ. Анх 2005 оны аравдугаар сард “Мэдээлэл авах эрх чөлөөний хууль”-ийн төслийг УИХ-ын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад орж байснаас хойш зургаан жилийн дараа гишүүдийн олонхийн саналаар УИХ-ын чуулганаар хэлэлцэхээр боллоо. Энэ хаврын чуулганаар тус хууль батлагдана гэдэгт Монголын олон нийт, сэтгүүлчдийн хамтын нийгэмлэг итгэж байна.

Төрийн зургаан байгууллагад хэвлэл мэдээлэл, мэдээллийн эрх зүйн чиглэлээр хуулийн 10 төсөл боловсруулж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр ажиллаж байна. Тагнуулын ерөнхий газрын ажлын хэсэг Төрийн нууцын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл дээр ажиллаж байгаа

бөгөөд Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар Мэдээллийн аюулгүй байдлын тухай, Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төслүүд дээр ажиллаж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага” баталж, 2011 оны гуравдугаар сарын нэгнээс мөрдөж эхэллээ.

Монгол Улс 2010 онд “Фрийдом хаус” олон улсын байгууллагын судалгаагаар хэвлэлийн хагас эрх чөлөөтэй орон хэвээр байна. “Хил хязгааргүй сэтгүүлчид” олон улсын байгууллагын үнэлж буйгаар хэвлэлийн эрх чөлөөний “мэдэгдэхүйц асуудал”-тай орны тоонд оржээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага 2010 оны хэвлэлийн эрх чөлөөний салбарт дараахь зүйлийг онцолж байна. Үүнд:

- “Нийгмийн толь” өдөр тутмын сонины толгой компьютерийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажилтнууд хураан авсан
- Шүүх, цагдаа, зохицуулах байгууллагуудын дарамт ихсэх хандлагатай байна
- Редакцийн цензур гүнзгийрч, шинж чанар нь ноцтой болж байна
- Сэтгүүлчдийн эсрэг үүсгэсэн эрүүгийн хэрэг нэмэгдэх төлөвтэй байна
- Нэхэмжлэлийн мөнгөн шаардлага гурван тэрбум, шүүхээс оногдуулсан торгуулийн хэмжээ 2009 онд 2 сая 200 мянгад хүрч, эдийн засгийн цензур болох хандлагатай байна.
- Шүүх, цагдаа, төрийн албан тушаалтнууд сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг шаардах нь буурахгүй байна

1999-2009 онд нэр төр, гүтгэлэг доромжлолтой холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний болон эрүүгийн 664 хэргийн 37,7 хувь нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг хэрэг байна. 2009 онд иргэний 17 хэрэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэмээн хариуцагчаар татагдсан.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг иргэний хэргийн мөнгөн шаардлага ба шүүхээс оногдуулсан торгуулийн хэмжээ жилээс жилд улам нэмэгдэж байна. 2009 онд торгуулийн хэмжээ 2 сая 200 мянгад, нэхэмжлэлийн мөнгөн шаардлага 2010 онд гурван тэрбумд хүрчээ.

2010 оны сүүлийн хагас жилээс 2011 оны тавдугаар сарын нэгэн хүртэл “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагад 18 сэтгүүлчийн мэргэжлийн эрхийн 30 зөрчил бүртгэгджээ. Сэтгүүлчийн нэг эрхийг зөрчихөд өөр нэг эрхэд нь халддаг юм. Нийт зөрчлийн 50-иас дээш хувь нь сүрдүүлэг, дарамт байсан бөгөөд зөрчигчдийн 75% нь эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид байв.

Сэтгүүлчдийн мэргэжлийн зөрчлийн нийтэд ил байгаа тухай дээрх тоо, хэлбэрүүд нь Монголын сэтгүүлчдэд тулгарч буй асуудлын дүр төрхийг гүйцэд төлөөлж чадахгүй. Учир нь, Монголд сэтгүүлчдийн өөрийн цензур маш өндөр бөгөөд тэдний олонх дараа нь ирэх дарамтаас айж, зөрчлийнхээ талаар ил мэдээлэхийг хүсдэггүйтэй холбоотой юм.

Тайлан үндсэн хоёр бүлэгтэй. Эхний бүлэгт 2010 оны хэвлэлийн эрх чөлөөний байдал болон сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлүүдийн жишээ баримтаас тусгав.

Тайлангийн хоёр дахь бүлэгт хэвлэл мэдээллийн эрх зүйн орчны тухай мэдээлэл багтаав.

НЭГ. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ 2010 ОНД

Монголд 2010 онд хэвлэл мэдээллийн 430 хэрэгсэлд 4080 орчим хүн ажиллаж байгаагийн 1781 нь сэтгүүлч, бусад уран бүтээлч ажилтан байна. Хэвлэл мэдээллийн нийт хэрэгслийн 20 хувь нь хөдөө орон нутагт ажилладаг. Монголд гадаад хэлээр зургаан сонин, үндэстний цөөнх болох казах хэлээр нэг сонин гарч байна.

Сүүлийн хоёр жилд онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо хоёроос гурван дахин нэмэгдсэнээс 2010 онд цахим сонин 5, цахим сэтгүүл 10 бүртгэгджээ. Өдөр тутмын таван сониныг цахим хуудаснаас уншиж, 12 радио, 11 телевизийн нэвтрүүлгийг интернэтээр сонсож, үзэж болно. www.sonin.mn цахим хуудаснаас 24 сонин уншиж болно¹.

Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг хамгаалсан хууль тогтоомж байгаа хэдий ч амьдрал дээр хэрэгждэггүй. Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийх, дарамт шахалт үзүүлэх, шүүх цагдаагаар сүрдүүлэх, мэдээлэл олж авах, түгээхэд нь саад хийх, редакцийн цензур, нууц эх сурвалжаа илчлэх албадлага, улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, хөрөнгө мөнгөтэй баячууд өөрсдийн буруутай үйлдлийг нуун дарагдуулахын тулд эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг цензур болгон ашиглах зэрэг зөрчил тасрахгүй байна. Сэтгүүлчийн мэргэжлийн эрх ийнхүү зөрчигдөж байгаа нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө боомилогдох, олон нийтийн үнэнийг мэдэх эрх зөрчигдөн, ардчиллын үнэт зүйлс алдагдахад хүргэж байна. Эдгээр ноцтой зөрчлүүд өнөө хэр нь буурахгүй байгаа нь манай улс олон улсын түвшинд хагас хэвлэлийн эрх чөлөөт орон хэмээн тооцогдож, Олон улсын өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хөсөрдүүлэхэд хүргэж байгаа билээ.

Улс төрчид, албан тушаалтан, төрийн албан хаагчид Эрүүгийн хууль, Иргэний хуулийн заалтуудыг цензур болгон ашиглах хандлага нэмэгдэж байна. Монголын шүүх нэр төр, гүтгэлэгтэй холбоотой хэргийг шийдвэрлэхдээ олон нийтийн үнэн мэдээлэл хүртэх хууль ёсны эрх ашгийг үл хүндэтгэн өрөөсгөл шийдвэр гаргаж байгаа нь шүүхийн шударга, хараат бус байдал алдагдсантай холбоотой хэмээн үзэж байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Нээлттэй Нийгэм Форум, Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2005 оны аравдугаар сараас сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийж эхэлснээс хойш 2011 оны 5-р сарын нэгэн хүртэл хугацаанд нийт 187 зөрчил бүртгэгдээд байна.

1 Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн “Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал- 2010” мониторингийн тайлан

Зөрчлийн тоо, хэлбэр

Зөрчлийн хэлбэр	2006	2007	2008	2009	2010	Нийт
Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан	3	3	6	-	-	12
Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан	16	7	23	13	10	59
Мэдээлэл өгөхөөс татгалзсан	8	10	13	2	-	33
Ажлын багаж хэрэгсэлд халдсан	3	3	2		2	8
Шүүх, хүчний байгууллагын дарамт	2	8	5	3	5	18
Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан	3	1	5	1	6	10
Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур	2	1	3	1	2	7
Эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулагдсан, хоригдсон	4	4	2	0	5	10
Нийт	41	37	59	20	30	187

Нийт зөрчлийн 50-иас дээш хувь нь сүрдүүлэг, дарамт байна. Сэтгүүлчдийн мэргэжлийн зөрчлийн нийтэд ил байгаа тухай дээрх тоо, хэлбэрүүд нь Монголын сэтгүүлчдэд тулгарч буй асуудлын дүр төрхийг гүйцэд төлөөлж чадахгүй. Учир нь, Монголд сэтгүүлчдийн өөрийн цензур маш өндөр бөгөөд тэдний олонх дараа нь ирэх дарамтаас айж, зөрчлийнхээ талаар ил мэдээлэхийг хүсдэггүйтэй холбоотой юм.

Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн мэдээг 21 аймаг, Улаанбаатар хот дахь нийт 22 мониторингоор дамжуулан хүлээн авч байсан юм. Харин 2010 оны сүүлээс өөрөө шуурхай мэдээлэх (self-alerting) мониторингийн шинэ систем нэвтрүүлснээр сэтгүүлчид хэн нэгнээр дамжуулах бус өөрөө өөрийнхөө тухай, мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд нь тохиолдож буй бэрхшээлийнхээ талаар бидэнд мэдээлэх боломжтой боллоо.

Сэтгүүлч Өөрөө шуурхай мэдээлэх (self-alerting) мониторингийн шинэ системд www.globeinter.org.mn/selfalerting хаягаар онлайн асуулга бөглөн олон нийтэд нээлттэй эсхүл хаалттай мэдэгдэх эсэхээ сонгон илгээнэ. Ингэснээр далд зөрчлүүдийн талаар мэдэх боломжтой болно гэж үзэж байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн тухай шуурхай мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үндэсний болон олон улсын сүлжээгээр, тухайлбал Чөлөөт илэрхийллийн олон улсын сүлжээ /IFEX/, Олон улсын сэтгүүлчдийн холбоо /IFJ/, Эрх чөлөөний ордон /Freedom House/, Хил хязгааргүй сурвалжлагчид /Reporters Without Borders/, Forum Asia, “19-р зүйл” зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмждэг олон улсын байгууллагууд, НҮБ-ын Хүний эрхийн комисс, Дэлхийн банк, Гадаадын элчин сайдын яамд, Монголд үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудад и-мэйл, цахим хуудас, хоёр сар тутмын “Глобын мэдээ” онлайн сонин бичиг, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тайлан зэрэг аргаар түгээж байна.

2010 оны сүүлийн хагас жилээс 2011 оны 5-р сарын нэгэн хүртэл “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагад 18 сэтгүүлчийн мэргэжлийн эрхийн 30 зөрчил бүртгэгджээ. Сэтгүүлчийн нэг эрхийг зөрчихөд өөр нэг эрхэд нь халддаг байна. Эрх нь зөрчигдөж, бидэнд мэдээлсэн сэтгүүлчдийн 85% нь өдөр тутмын сонин, 15% нь телевизийнх байна. Эдгээр зөрчлийн олонх нь буюу 86,7 % нь Улаанбаатар хотод, 13,3 % нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Мэргэжлийн эрхийн зөрчлийн хэлбэрийг нь ангилбал:

- Хэвлэн нийтэлсний төлөө эрүүгийн хэрэгт буруутгасан 5
- Шүүхэд нэхэмжлэл гаргасан 5
- Ажлын багаж хэрэгсэл хураан авсан 2
- Айлган сүрдүүлсэн 10
- Нууц эх сурвалжаа илчлэхийг шаардсан 6
- Редакцийн цензур 2

Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг зөрчигчдийн 75% нь эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид байв.

“Глоб Интернэшнл” төрийн байгууллага 2010 онд гарсан сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн дараахь зөрчлүүдийг онцолж байна.

2010 онд төрийн байгууллага, шүүх, цагдаа, хууль сахиулах байгууллагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл цуглуулах, сурвалжлах үйл ажиллагааг зүй бусаар, үндэслэлгүй хязгаарлах, сэтгүүлчийг айлган сүрдүүлсэн хэвлэл мэдээлэлд дарамт учруулсан тохиолдлууд гарсан байна. Эдгээр нь сэтгүүлчийн үйл ажиллагаанд цензур болдог мэргэжлийн эрхийн ноцтой зөрчлүүд юм.

ШҮҮХ, ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРАМТ

Өдөр тутмын нэгэн сонины сэтгүүлч Б /нэрээ хэлэхийг хүсээгүй/ хууль сахиулах байгууллагын анхаарлыг хандуулж, олон нийтийг сэрэмжлүүлэх зорилгоор манай улсад шинээр гарч буй залуусын гэмт бүлэглэл, тэдний үйлдлийн тухай мэдээлжээ. Ингэхдээ тохиолдож болзошгүй эрсдлээс өөрийгөө хамгаалахын тулд нэрээ бичээгүй байна. Нийтлэлийн дараа нийслэлийн цагдаагийн ажилтан М тухайн мэдээлэл гарсан нүүрний материалыг бэлтгэсэн эмэгтэй сэтгүүлч Т-г дуудаж, “мэдээллийн эх сурвалжтай хамтарч ажиллана, хүндрэл учруулахгүй” гэж амалсанд итгэсэн сэтгүүлч, уг нийтлэлийг Б бичсэн болохыг илчилжээ. Харин Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн ахлах дэслэгч О редакцийн байрны гадаа сэтгүүлч Т-г дахин дуудан уулзахдаа айлган сүрдүүлж, цүнхийг нь нэгжин дуу хураагуурыг нь хураажээ. Мөн сэтгүүлч Б-г дуудан хэргийн газар руу дагуулан очсоны дараа цагдаагийн хэсэг дээр авчиран байцаалт авахдаа “нийгэмд айдас дагуулсан” хэмээн буруутган “шоронд хорих”-оор сүрдүүлсэн байна. Тэгэхдээ “сурвалжлагыг зохиож бичсэн” гэсэн хуурамч мэдүүлгэн дээр сэтгүүлчээр гарын үсэг зуруулж, сониндоо залруулга гаргахыг шаардсан байна.

“Нийгмийн толь” сонин 2009 оны есдүгээр сарын нэгний өдрийн дугаарынхаа “Уншигчийн захидал” буланд Засаг даргынхаа ажил байдлыг шүүмжлэн, холбогдох албан тушаалтнуудын хуульд нийцээгүй үйл ажиллагааг буруушаасан Баян-Өлгий аймгийн иргэдийн нэргүй захидлыг нийтэлжээ. Сонины нийтлэлийн дараа аймгийн долоон албан тушаалтан Чингэлтэй дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Анхан шатны шүүх сониныг тухайн албан тушаалтнуудын нэр төрд халдсан хэмээн буруутгаж, залруулга нийтлэх, мөн 1.698.500 төгрөгийн торгууль төлүүлэхээр шийдвэрлэжээ. 2010 оны 8-р сарын 27-ны өдөр ажил тарах үеэр ШШГЕГ-ын ажилтнууд сонины редакцид ирж, тогтоосон хугацаанд нь төлөөгүй торгуулийн оронд нууцын зэрэглэлтэй баримт материалууд агуулсан толгой компьютерийг хураан авчээ. Сонины ажилтнуудад компьютерээ лацдах боломж ч олгосонгүй. Мөн өөр компьютерээр солих, эсвэл өөр эд хөрөнгө өгөх сонины удирдлагын саналыг хүлээж аваагүй байна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРАМТ

Монгол улсын Их хурал

Монгол Улсын Их Хурлын 2010 оны арванхоёрдугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль”-ийн “УИХ-ын үйл ажиллагааг мэдээлэх журам”-д “УИХ-ын үйл ажиллагааг сурвалжлах эрхийг чуулган бүрийн эхэнд хэвлэл, мэдээллийн байгууллагаас ирүүлсэн санал, ажлын туршлага, мэргэжлийн ур чадварыг харгалзан хэвлэл мэдээллийн ажилтны нэр зааж олгоно” гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулсан юм.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага, “Монгол Улсын Их Хурлын сэтгүүлчдэд ялгавартай хандсан дээрх шийдвэр нь сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг зөрчөөд зогсохгүй хэвлэл, мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийнхээ ажил үүргийг өөрсдөө зохицуулан хуваарилдаг дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцож тухайн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх чөлөөнд халдсан үйлдэл болсон байна. Энэ нь сэтгүүлч, хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх үйл явцад цензур тавьж буй хэрэг бөгөөд ингэснээр аливаа хэлбэрийн цензурыг хориглосон Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн заалтыг ноцтой зөрчиж байгаагийн илрэл хэмээн үзэж байгаагаа илэрхийлж, мэдэгдэл гаргав.

Дээрх хуулиар сэтгүүлчдийн УИХ-ын Байнгын Хорооны хурал сурвалжлах эрхийг хязгаарласан нь хэвлэл мэдээллийнхний хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан. Сэтгүүлчдийг дэмжсэн УИХ-ын хэсэг гишүүдийн санаачилгаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн шинэ төслийг өргөн барьсаны дагуу 2011 оны 1-р сарын 20-ны УИХ-ын чуулганы хуралдаанаар гишүүдийн 84,1 хувийн саналаар Байнгын хорооны хуралдаан сэтгүүлчдэд нээлттэй болсон юм.

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо

2010 онд 4-р сарын 5-ны өдөр Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Ийгл” телевизэд албан бичиг хүргүүлжээ. Албан бичигт “Сүүлийн өдрүүдэд улс оронд болж буй үйл явдлыг сурвалжлах, өөрийн телевизийн сувгаар нэвтрүүлж байгаа байдал нь хүчирхийлэлд уриалан дуудах, Үндсэн хуулийн бус арга замаар

засгийн эрхийг авах, нийгмийн тогтворгүй байдалд уриалсан улс төрийн болон иргэний хөдөлгөөний холбогдолтой нэвтрүүлгийн давтамжийг эрс нэмэгдүүлэх замаар нийгэмд эмх замбараагүй байдал, бослого, төрийн эсрэг хүчирхийлэлд дэмжлэг үзүүлж болзошгүй үйл ажиллагаа болж болохыг танай телевизэд анхааруулж байна” гээд ийм үйлдэлд оролцсон тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах үндэслэл болохыг сануулсан байна.

Ийгл телевизийн хамт олон тухайн өдрүүдэд Улаанбаатар хотод болж байсан Ард түмний амлалт нэхэх хөдөлгөөний жагсаал цуглаанаас шууд сурвалжлан олон нийтэд мэдээлж байжээ.

Улсын ерөнхий прокурор Д.Дорлигжав

“Өдрийн шуудан” сонины эрэн сурвалжлах албаны дарга, сэтгүүлч Б.Цоожчулуунцэцэг 2010 оны 12 дугаар сараас бичиж эхэлсэн “Банк дампууруулсан тэрбумтанууд” цуврал нийтлэлийнхээ 3 дугаарт (2010.12.9-ний өдрийн 283/361/) “УЕП Д.Дорлигжав 827 мянган ам долларын өртэй гэв үү?” дэд гарчигтай мэдээлжээ.

Уг нийтлэлтэй холбогдуулан 2010 оны 12-р сарын 17-ны өдөр Ерөнхий прокурорын туслах, УЕПГ-ын мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга М.Болд “энэ нийтлэл гэмт хэргийн шинжтэй тул шалгах” хүсэлт гаргаж цагдаагийн байгууллагад албан тоот хүргүүлжээ. Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтэс хэрэг бүртгэлт явуулж “эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй” гэсэн хариу өгсөн боловч Сүхбаатар дүүргийн Прокурор 2010 оны 12-р сарын 23-ны өдөр эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага тус хэрэгтэй холбогдуулан үндэсний болон олон улсын сүлжээгээр шуурхай мэдээ түгээж, Ерөнхий прокурор Д.Дорлигжавт хандан албан захидал хүргүүлсэн.

Захидалдаа Ерөнхий прокурорыг нэр төрөө сэргээлгэхийн тулд Иргэний хуулийн дагуу гомдол гаргах боломж байсан атал Эрүүгийн хууль сонгосны дээр түүний туслах, мөрдөн байцаах үйл ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ерөнхий прокурорын хувийн нэр төртэй холбоотой асуудлаар өргөдөл гаргасан нь хэргийг шалгаж буй мөрдөн байцаагчид ажил үүргээ шударгаар гүйцэтгэхэд нөлөөлөх, сэтгүүлчийг эх сурвалжаа илчлэх дарамт, шахалтанд өртөхгүй гэдэгт эргэлзэж буйгаа мэдэгдэв.

Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг айлган сүрдүүлэх, дарамтлах цензур болгон ашиглаж байгаа нь “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглох” Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль зөрчсөний дээр сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх нь Эрүүгийн хуулийн 139-р зүйлд зааснаар гэмт хэрэг болохыг сануулсан юм.

УИХ-ын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх

Сэтгүүлч, нийтлэлч А.Баатархуяг “Өдрийн сонин”-ы 2010 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 48, 49 дугаарт “Нэгдлээс задрал руу” нийтлэл өөрийг нь гутаан доромжилсон хэмээн үзэж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

Л.Гансүх цагдаагийн байгууллагад гомдол гаргажээ. Тэрээр өргөдөлдөө “Энэ хэргийн үнэн мөнийг олж, орон даяар гүтгэлэг тарааж, авлигын хүнд гэмт хэрэгт гүтгэсэн Баатархуягт хуулийн дагуу хатуу арга хэмжээ авахыг хүсч байна” гэсэн байна. Прокурорын байгууллага эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэн, асуудлыг иргэний журмаар шийдвэрлүүлэхийг хоёр ч удаа зөвлөсөн боловч сайд Л.Гансүх “Заавал эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсний дагуу 2010 оны 7-р сарын 8-ны өдөр Сүхбаатар дүүргийн прокурор эрүүгийн хэрэг үүсгэжээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага сэтгүүлчид Эрүүгийн хэрэг үүсгэсэн явдалд түгшиж буйгаа мэдэгдэн, үндэсний болон олон улсын сүлжээгээр шуурхай мэдээ түгээсэн.

Мөн УИХ-ын гишүүн, БОАЖЯ-ны сайд Ц.Гансүхт эсэргүүцлийн албан захидал илгээн “...Та бол олон нийт, хэвлэл мэдээллийн хараа хяналтад байдаг, олон улсын жишгээр бол шүүмжлэлд өртөмтгий бүлэгт багтдаг төрийн өндөр албан тушаалтан билээ. Та иргэний хувьд өөрийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлд хариу өгөх эрхтэй. Танд хүссэн хэлбэрээр дээрх мэдээлэлд хариу өгөх, няцаах эрх, боломж нь ч бий. Нэр төрөө сэргээлгэхийг хүсвэл Иргэний хуулийн холбогдох зүйл заалтын дагуу гомдол гаргах боломжтой. Таны энэ үйлдэл эрүүгийн хуулийн зүйл заалтыг ашиглан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагыг айлган сүрдүүлэх, дарамтлах цензур болон хувирч болзошгүй ... Чөлөөт, хараат бус хэвлэл, хэвлэлийн эрх чөлөөний мөн чанар, ач холбогдол, түүний ардчилалд оруулах хувь нэмэр Таны хувийн нэр төрөөс илүү жинтэй болохыг ардчиллын үнэт зүйлсийг дээдлэгч, тэмцэгч Та ухамсарлан ойлгоно гэдэгт найдаж байна” хэмээн мэдэгдсэн юм.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Нэгдсэн лабораторийн эрхлэгч Д.Цэндээхүү

“Өдрийн шуудан” сонины албаны дарга, сэтгүүлч Ч.Чулуунцэцэг 2011 оны 3-р сарын 15-ны дугаартаа “Ах нь арыг нь дааж, дүү нь мөнгө босгодог тогтолцоо монголынх” гарчигтай нийтлэл бичжээ. Уг нийтлэлд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Нэгдсэн лабораторийн эрхлэгч Д.Цэндээхүүг эрхэлж буй албан тушаалтай нь холбон шүүмжилсэн байна. Түүнийг мэргэжилдээ тэнцэхгүй байсаар атал өндөр албан тушаал эрхэлдэг ахынхаа ачаар суудалдаа бат гагнагдсан, албан тушаалаа ашиглан зохисгүй үйлдэл хийж байгаа талаар бичжээ. Цэндээхүүгийн удирдаж буй лаборатори 2005 оноос хойш шинжилгээнд ирсэн бүхий л бүтээгдхүүнийг химийн аргаар судлаад, гарсан хаягдал, химийн бодисын үлдэгдэл, шавхрууг крант руугаа, заримыг нь хойд хаалгаараа гарган модны ёроолд асгадаг талаар нэрээ хэлэхийг хүсээгүй эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан баримттай бичсэн байна. Энэ нийтлэлээс үүдэн Д.Цэндээхүү нэр төр гутаасан хэмээн гомдол гаргасны дагуу, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтэст сэтгүүлчийн эсрэг Эрүүгийн хэрэг үүсгэн, шалгагдаж байна.

БИЗНЕСМЭН, ХӨРӨНГӨ МӨНГӨТЭЙ ХҮМҮҮСИЙН ДАРАМТ

“Мон-Уран” компаний захирал Б.Наранхүү

“Зууны мэдээ” сонин нь хүний наймаа болон насанд хүрээгүй охидыг бэлгийн мөлжлөгөд ашиглаж байгаа талаар 20 гаруй цуврал нийтлэл, сурвалжлага бэлтгэн нийтлүүлжээ. Тус сонины эрэн сурвалжлах албаны сэтгүүлч Д.Болормаа бага насны (дунд сургуулийн 14-15 насны сурагчид) охидын онгон биеийг 500 ам.доллараар худалддаг, худалдан авдаг зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ байгааг илрүүлж, энэ хэрэгт эрх мэдэлтэй, хөрөнгө чинээтэй хүмүүс холбогдсон болохыг гэрч, хохирогчдын яриагаар баталгаажуулан, “Мон-Уран” компаний захирал Б.Наранхүү гэдэг хүн үүнд холбоотой гэдгийг 2010 оны 11 дүгээр 8-ны өдрийн 267 дугаартаа “Мон-Уран”-ы Б.Наранхүү өсвөр насны охидыг садар самуунд уруу татсан хэргээр шалгагдаж эхэллээ” гарчигтайгаар нийтэлсэн байна.

Нийтлэлийн дараа “Мон-Уран” компаний захирал Б.Наранхүү “Зууны мэдээ” сониноос нэр хүндийн төлбөр хэмээн 3 тэрбум төгрөг нэхэмжлээд зогсохгүй тус нийтлэлийг бичсэн сэтгүүлч Д.Болормаад эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргажээ. Мөн сэтгүүлчийг шүүх, цагдаагаар далайлган сүрдүүлэх, нэр төрийг нь гутаан доромжилсон мэдээлэл тараах, утсаар айлган сүрдүүлсэн тохиолдол нэг бус удаа гарсан байна.



Уг хэрэгтэй холбогдуулж “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага үндэсний болон олон улсын сүлжээгээр илгээсэн шуурхай мэдээний дагуу Олон улсын сэтгүүлчдийн холбооноос мэдэгдэл ирүүлсэн юм. Олон улсын сэтгүүлчдийн холбооны Ази, Номхон Далайн бүсийн захирал Жаклин Парк “Олон улсын сэтгүүлчдийн холбоо Монголын эрх баригчдыг гүтгэлэг, доромжлол, нэр төр гутаах эрүүгийн болон иргэний хуулийг сурвалжлагч, хэвлэл мэдээллийн



Би “Зууны мэдээ” сонины 2010 оны 11 дүгээр сарын 08-ны дугаарт “Мон-Уран” компаний захирал Б.Наранхүүг өсвөр насны охидыг садар самуунд уруу татсан хэргээр шалгаж байна” гэсэн нийтлэл бичсэн. Нийтлэлээ хоёр эх сурвалж буюу хэргийн хохирогч болон албаны хүний мэдээлэлд түшиглэн бичсэн. Мэдээлэл гарсны дараахан Б.Наранхүү намайг өөрийнх нь нэр хүндэд ноцтойгоор халдсан хэмээн цагдаагийн байгууллагад гомдол, шүүхэд гурван тэрбум төгрөгийн нэхэмжлэл гаргасан. Гомдлын мөрөөр надад Эрүүгийн хуулийн 111.2-т заасан үндэслэлээр хэрэг үүсгэн шалгаж, “Зууны мэдээ” сониноос гурван тэрбум төгрөг нэхэмжилсэн юм. Өөрөөр хэлбэл, эрүү, иргэний хэрэг давхар “үүрүүлсэн” гэсэн үг. Харин Сүхбаатар дүүргийн шүүх 2010 оны хоёрдугаар сард гурван тэрбум төгрөгийн нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянан хэлэлцээд “Нэхэмжлэл үндэслэлгүй байна. Нөгөө талаас энэ хэргийг эрүүгийн хэргээр шийдвэрлэх нь зүйтэй” хэмээн хаасан. Надад холбогдох эрүүгийн хэргийг прокурорын шатанд яллах дүгнэлт үйлдүүлэхээр явуулсан.

Харамсалтай нь, би нийтлэлийг бичихдээ хэн нэгнийг санаатай гүжирдэж, нэр хүндэд нь халдах зорилго агуулаагүй. Бодит мэдээлэл буюу эх сурвалжуудын мэдээлэлд үндэслэн бичсэн. Өөрөөр хэлбэл, түүнийг охидын онгон биеийг худалдан авдаг байсныг гэрчлэх гэрчүүд бий. Гэрчүүд энэ тухай холбогдох байгууллагад мэдүүлсэн ч Б.Наранхүүгээс нэг ч удаа байцаалт аваагүй. Харин нийтлэлийн дараа өөр нэгэн Г.Наранхүүг холбогдуулан шалгаж байгаа гэх юм билээ. /Г.Наранхүү нь Сингапур руу оргон зугатсан/. Түүгээр зогсохгүй зуучлагч охид “Мон-Уран”-ы Б.Наранхүү мөн гэж мэдүүлэг өгсөн охиныг “Чи мэдүүлгээсээ буц” хэмээн хэл амаар доромжлон нөлөөлөхийг оролдсон байсан. Мөрдөн байцаалтын нууц яагаад задрав гэдэг нь анхаарал татсаар байна. Цагдаагийн байгууллага намайг эх сурвалжаа хэл хэмээн шалгааж байхын оронд гүйцэтгэх ажлаар хэргийг илрүүлээч гэдгийг удаа дараа уламжилсан. Харамсалтай нь, ямар ч дорвитой үр дүн гарахгүй байна. Энэ хэрэг 2008 оноос хойш үйлдэгдсэн гэх бөгөөд дунд сургуулийн 14-18 насны 17 охин уг хэрэгт их, бага хэмжээгээр хамааралтай.

Асч буй гал руу дайран орохоос ч буцахгүй залуу насны минь зүрх зориг энэ явдлаас хойш няцсан, бас мохсон. Мөнгөтэй, танилтай хүний буруутай үйлдлийг нүд, чихээ таглан дуугүй өнгөрүүлж, өөгшүүлэх ёстой нийгэмд амьдарч байгаагаа ухаарсан. Би хэн нэгний ашиг сонирхлын дагуу буруудаж болно. Гэхдээ 14-18 насны цэцэг цэврүү шиг охидын ирээдүй гэгээлэг байгаасай. Тэд санхүүгийн эмзэг байдлаасаа болж алдсаных нь төлөө насан туршийнх нь амьдралд хар толбо бүү үлдэг. Шударга ёс гэж байдаг бол хэргийн үнэн мөн олдоно гэдэгт итгэж байна.

**“Зууны мэдээ” сонины эрэн сурвалжлах, шуурхай
мэдээллийн албаны сурвалжлагч Д.Болормаа**

байгууллагыг цагдан хянахад урвуулан ашиглахгүй байхыг шаардаж байна” хэмээн мэдэгдээд сэтгүүлч Дамдинсүрэнгийн Болормаагийн аюулгүй байдлыг хангахад анхаарлаа хандуулахыг Монголын эрх баригчдад уриалсан байна.

“Глоб Интернэшнл” 2010 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хэвлэлийн бага хурал хийж, эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйл заалтыг сэтгүүлчийн эсрэг хэрэглэх, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг бүрэн дампуурч, зогсооход хүргэж болзошгүй их хэмжээний төлбөр нэхэмжилснийг эсэргүүцэж байгаагаа мэдэгдлээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага 2010 оны 11 дүгээр сард 13 аймгийн 86 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг хамарсан зайны сургалт зохион байгуулсан юм. Сургалтын дараа орон нутгийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тохиолдож байгаа бэрхшээлүүдийнхээ талаар ярьж зөвлөгөө авсан юм.

2010 онд Хэнтий аймгийн гурван сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг утсаар заналхийлсэн дөрвөн удаагийн тохиолдол гарчээ. Мэдээлэл өгөхөөс татгалзсан нэг зөрчлийн тухай “Хэнтийн Мэдээ” сонин тухайн үед ил тодоор нийтэд зарласан. “Дөлгөөн Хэрлэн” радиостанцын сурвалжлагчийг аймгийн ЭМГ-ын удирдах албан тушаалтан нэвтрүүлгээ нийтэд цацахаас өмнө хянуулах, хүсээгүй мэдээллээ хасахыг шаардсан.

Сэтгүүлчдийн ихэнх нь мэргэжлийн эрх нь зөрчигдсөн тухай олон нийтэд мэдээлэхийг хүсэхгүй байна. Гэхдээ тэд дахиад дарамтлах, ажлаас халагдах гэх мэт тодорхой шалтгаанаа ч нэрлэхийг хүсдэггүй юм.

Хэнтий аймаг. Сэтгүүлчдийн салбарын тэргүүн Б.Адьяахүү

Орон нутагт мэргэжлийн эрхийн зөрчил алхам тутамд тохиолддог бөгөөд тохиолдож буй бэрхшээл нь нийтлэг, адил төстэй ажээ. Тухайлбал, төрийн байгууллагаас мэдээлэл олж авахад хүндрэлтэй, нийтэлсэн, нэвтрүүлсэн материалаасаа болж шүүхэд дуудагдах нь түгээмэл байна. Орон нутагт мэргэшсэн өмгөөлөгч дутагдалтай тул анхан шатны шүүх хурал дээр хэвлэл мэдээллийнхэн ялагдах нь цөөнгүй. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрийн байгууллага далдуур өмчлөн өөрсдийгөө сурталчлах хэрэгсэл болгон хууль зөрчдөг, сэтгүүлчдийг улс төрийн нүдээр харж ялгаварладаг, мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаарддаг зөрчил байсаар байна. Бие даан үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл дарамтанд орж, санхүүгийн хараат байдалтай болдог, орон нутгийн сэтгүүлчдэд мэргэжлийн ажлаа гүйцэтгэх нь жилээс жилд хүнд болж, залуу сэтгүүлчид залхдаг, улмаар энэ нь мэргэжилтэй боловсон хүчин дутагдахад хүргэж байна.

Иргэний болон Эрүүгийн хуулийг цензур болгон ашиглаж буй нь

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага бичиж нийтлүүлсэн зүйлийнхээ төлөө сэтгүүлчид Эрүүгийн хуулиар шийтгүүлэх ёсгүйг байнга сануулдаг. Олон улсын хэм хэмжээ, эрх зүйгээр “Гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь хүний нэр төрийг хамгаалахад онцын шаардлагагүй бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг учраас хүлээн зөвшөөрөх боломжгүй” хэмээн үздэг.

Сэтгүүлчийг шүүмжлэлт нийтлэл бичсэнийх нь төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал буурахгүй харин ч нэмэгдэж байна. 2010 онд эрүүгийн хэрэгт шалгагдсан 5 сэтгүүлч “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагад хандсан юм.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг иргэний хэрэгт нэхэмжилж буй торгуулийн хэмжээ жилээс жилд улам нэмэгдэж байна. 2010 онд “Зууны мэдээ” сониноос гурван тэрбум төгрөг, “Монголын үнэн” сониноос 30 сая төгрөг нэхэмжилсэн нь урьд өмнө гарч байгаагүй өндөр мөнгөн шаардлага байв. “Зууны мэдээ” сонинд холбогдох нэр төрөө сэргээх хэргийг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон байна. Харин “Монголын үнэн” сонины эсрэг 30 сая төгрөгийн

нэхэмжлэлтэй иргэний хэргийн шаардлагыг анхан болон давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн тул хяналтын шатны шүүхэд хандаад байна. Тухайн хэргийн нэхэмжлэгч болох хүний наймааны хохирогч эмэгтэй шүүх хурлын танхимаас хийсэн сурвалжлагадаа өөрийнх нь нэрийг бүтнээр бичсэнээр нэр төрд халдаж, гэм хор учруулсан гэж үзэн сэтгүүлчийг буруутган шүүхэд нэхэмжлэл гаргасан. 30 сая төгрөг нь тухайн сониныг санхүүгийн хүнд байдалд ороход нөлөөлөхүйц их хэмжээний торгууль гэж үзэн бид эсэргүүцэж байгаа юм.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Монгол улсын хэмжээнд 2009 онд шүүхээр шийдвэрлэсэн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой иргэний эрх зүйн маргаан, бусдыг гүтгэсэн, доромжилсон гэх эрүүгийн хэрэг, эдгээрээс сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох, түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжсан мэдээлэлтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдалд судалгаа хийсэн юм.

Судалгааг нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тухай шүүхээр хянан шийдвэрлэгдсэн иргэний хэрэг, маргаан, бусдыг гүтгэсэн, доромжилсон эрүүгийн хэргүүдийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байдлыг судлан, Иргэний болон Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага хэрхэн ашиглаж буйг илрүүлэх зорилгоор жил бүр хийж байна.

Монгол улсын Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлүүдэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, учирсан гэм хорын хохирлыг арилгах, Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд доромжлох, 111 дүгээр зүйлд гүтгэх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохоор тус тус зохицуулсан байдаг.

Судалгаа хийх явцад дараах мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Нийслэлийн шүүхийн архивт буй есөн дүүргийн шүүхийн баримт бичгүүдтэй танилцан дэлгэрэнгүй жагсаалт гаргав.
- Дурьдсан хугацаанд шийдвэрлэсэн хэргийн талаар судалгаа ирүүлэхийг хүссэн албан бичгийн дагуу 21 аймгийн шүүхээс ирүүлсэн судалгааны мэдээлэл

Нэр төр сэргээх нэхэмжлэлтэй иргэний хэргийн тоо сүүлийн 10 жилийн дотор 2009 онд хамгийн олон гарсныг харахад ийм төрлийн хэрэг цаашдаа ч өсөх хандлагатай байна. Харин 2009 онд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг иргэний хэргийн тоо буурч, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолын хэрэг шийдвэрлэгдээгүй байна.

Монгол Улсын хэмжээнд 2009 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаасантай холбоотой 44, гүтгэлэг доромжлолтой холбоотой эрүүгийн нэг хэрэг бүх шатны шүүх, прокурорын байгууллагаар хянан шийдвэрлэгдсэн байна. Үүнээс иргэний 17 хэрэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэмээн хариуцагчаар татагдсан.

Нутаг дэвсгэрийн хувьд Улаанбаатар хотод 13, орон нутагт шийдвэрлэсэн хэргийн дөрөв нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн эсрэг нэхэмжлэлтэй хэрэг байлаа.

2008 онд нэхэмжлэгчдийн 65 хувь нь эрх мэдэлтэн, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид байсан бол энэ тоо 2009 онд 73 хувь болж

өссөн нь Иргэний, Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, цензур тавихад ашиглах нь нэмэгдэж байгааг харуулж байна.

Нэхэмжлэлийн мөнгөн шаардлагын хэмжээ, шүүхээс ногдуулж буй торгуулийн хэмжээ 2008 оныхтой харьцуулахад нэмэгджээ. 2008 онд торгуулийн хэмжээ нэг сая төгрөг байсан бол 2009 онд 2 сая 200 мянгад хүрч, торгуулийн доод хэмжээ Улаанбаатарт таван зуун мянган төгрөг, хөдөө орон нутагт хоёр зуун мянган төгрөг байгаа нь тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн санхүүгийн байдалд бодитой хохирол учруулж болзошгүй байна.

Шүүхээр шийдвэрлэсэн байдлаас харахад, ялагдсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн тоо нэмэгджээ. 2008 онд иргэний хэргийн 71.4 хувьд шүүх сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл буруутай гэсэн шийдвэр гаргасан бол 2009 онд энэ тоо 82.4 хувьд хүрчээ.

Өмнөх онуудын хэргүүдтэй харьцуулсан үзүүлэлт

Он	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг	
	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах хэрэг	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах хэрэг
1999	30		3	
2000	39			
2001	31	11	4	
2002	44	37	2	2
2003	28	18	1	1
2004	40	40	1	1
2005	29	25	1	1
2006	36	31	3	3
2007	33	33	-	-
2008	39	25	5	5
2009	44	17	1	-
Бүгд	393	237	21	13

1999-2009 онд нэр төр, гүтгэлэг доромжлолтой холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний болон эрүүгийн 664 хэргийн 37,7 хувь нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг хэрэг байна.

ХОЁР. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ

2.1. Эрх зүйн салбарт гарсан өөрчлөлт

2010 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөс хойш монголын хэвлэл мэдээлэл, мэдээллийн эрх зүйн салбарт бодлого, зохицуулалтын олон баримт бичиг, дүрэм журам батлагдаж, хуулийн төсөл боловсруулснаараа онцлог боллоо. Орчин үеийн мэдээллийн шинэ технологийн хөгжил, уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн цахимжилт, шинэ хэвлэл мэдээллийн хурдацтай дэвшил, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, ялангуяа өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн тоо нэмэгдэж буй зэрэг нь ийм хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага 2011 оны гуравдугаар сард 1957-2010 онд батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж буй 418 хууль, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 1287 хуульд судалгаа хийсэн. 2010 оны 12-р сарын 31-ний байдлаар 188 хуульд мэдээллийн эрх чөлөө, төрийн байгууллагын ил тод байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө, хэвлэл мэдээллийн харилцааг зохицуулсан зүйл, заалт оржээ. 2001 онд “19-р зүйл” олон улсын байгууллагатай хамтран хийсэн судалгаагаар тухайн үед үйлчилж байсан 91 хуульд дээрх зохицуулалт тусгагдсан байсан юм.

2010 онд Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас доорхи нэр бүхий бодлогын хэд хэдэн чухал баримт бичиг баталжээ. Үүнд:

- 2010-2015 онд хэрэгжүүлэх “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 141 тогтоолоор батлагдсан.
- “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. УИХ-ын 2010 оны долоодугаар сарын 15-ны өдрийн 48 тоот тогтоолоор шинэчлэн баталсан. Шинэ үзэл баримтлалд “Мэдээллийн аюулгүй байдал”-ыг хангах тусгай бүлэг анх удаа орсон байна. Энэ үзэл баримтлал хүний эрхэд суурилсан, иргэдийн оролцоог хангах, иргэдэд хүртээмжтэй байхыг үүрэг болгосон зэрэг илүү дэвшилттэй болсон байна.
- “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр” Засгийн газар 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 275 тоот тогтоолоор баталсан. Энэ хөтөлбөрт тусгаснаар Монгол Улсад аналогич технологи ашиглан радио, телевизийн өргөн

нэвтрүүлэг дамжуулах сүлжээний үйл ажиллагааг 2014 оны долоодугаар сарын 31-ний өдрийн 00 цагт бүрэн зогсоож, тоон технологид шилжинэ.

- “Радио, телевизийн үйлчилгээг зохицуулахад баримтлах чиглэл” Засгийн газрын 2010 оны 10-р сарын 27-ны өдрийн 276 тоот тогтоолоор батлагдсан энэ тогтоолын дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага” баталсан.

Үүнээс гадна төрийн дараахь байгууллагуудад хэвлэл мэдээлэл, мэдээллийн эрх зүйн чиглэлээр хуулийн 10 төсөл боловсруулж байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газар

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,

УИХ-ын ажлын хэсэг

- Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл

Засгийн газрын хэрэг эрхлэх газар

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл
- Цахим гарын үсгийн тухай хуулийн төсөл

ХЗДХЯ

- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төсөл
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Тагнуулын ерөнхий газар

- Төрийн нууцын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
- Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл

Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар

- Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл
- Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл

Монгол улсын Засгийн газар “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай” хуулийн төслийг 2011 оны нэгдүгээр сарын 21-ний өдөр УИХ-д өргөн барьжээ. УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо тус хуулийн төслөөр нээлттэй сонсгол зохион байгуулж, иргэний нийгмийн

байгууллагуудаас санал авсаны дараа 2011 оны дөрөвдүгээр сарын 21-ний өдрийн УИХ-ын чуулганы хуралдаанаар хуралд оролцсон гишүүдийн 86.6 хувийн саналаар хуулийн төслийг хэлэлцэхээр шийдвэрлэсэн байна. Энэ хуулийн төсөлд иргэдийн төрийн байгууллагаас хүссэн мэдээллээ авах эрх, эрх чөлөөг хангахын зэрэгцээ өөрийн үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, төрийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох үүргийг төрийн байгууллагуудад үүрэг болгохоор тусгажээ.

Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Оюун, Ц.Мөнх-Оргил, Сү.Батболд, Э.Бат-Үүл нар санаачлан 2007 оны тавдугаар сарын хоёрны өдөр УИХ-д өргөн барьсан юм. Уг хуулийн төслийг Төрийн бус байгууллагуудын удаа дараагийн санал зөвлөмжийг үндэслэн шинээр боловсруулсан ч өнөөг хүртэл батлагдаагүй юм.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2011 оны хоёрдугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар баталсан “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ыг 2011 оны гуравдугаар сарын нэгнээс тус тус хэрэгжүүлж эхэлсэн.

Харилцаа холбооны зохицуулах хороо дээрх Ерөнхий нөхцөл шаардлагын хяналтыг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Оюуны өмчийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын Ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран хийхийн зэрэгцээ Зохицуулах хороо байнгын мониторинг, хяналт тавих тогтолцоог бий болгоно гэжээ. Нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу радио, телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ, контентын үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрх нь Зохицуулах хороонд ноогдож байгаа нь төрийн байгууллагуудаас хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих цензур болж байна гэж “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага үзэж байгаа юм.

2.2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Монгол Улс Үндсэн Хууль болон бусад хууль тогтоомжоор иргэдийнхээ үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлтэй байх, хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулсан байдаг.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан юм.

- 16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.
- 16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

Монгол Улс НҮБ-ын гишүүний хувьд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн. 1974 онд Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактад нэгдэн орсон. Иймд Монгол Улс дээрх хоёр бичиг баримтын 19-р зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг олон улсын эрх зүйн дагуу хамгаалах үүрэгтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар дээрх зүйл заалт дотоодын хууль адил хүчин төгөлдөр байна.

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139-р зүйлээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх нь гэмт хэрэг гэж үзсэн юм. Гэсэн хэдий ч Монголд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх, эрх чөлөөг хязгаарласан олон хууль үйлчилж байна.

2.3. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт

Монгол Улсад төрийн нууцыг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар хамгаалдаг. Төрийн нууцын тухай хууль 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2004 оны 1-р сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Төрийн нууцын тухай хуульд: “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологии, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Хуулийн 11-р зүйлд зааснаар “Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно” гэсэн бөгөөд төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн гурван зэрэглэлтэй байна.

Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцыг үндсэн 5 төрөлд ангилдаг. Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар 59-н зүйлийн мэдээллийг, тухайлбал үндэсний аюулгүй байдлын хүрээнд 19, батлан хамгаалах хүрээнд 14, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 5, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 15, бусад хүрээнд 6 зүйлийн мэдээллийг нууцлахаар тогтоожээ. Нийт 59 зүйлээр тогтоосон мэдээллийн 69.5 хувийг 40-60 жилээр, эсвэл байнга нууцалсан байна.

Нууцалсан зэрэглэлээр үзвэл онц чухал-маш нууц мэдээлэл 6, маш нууц мэдээлэл 24, нууц мэдээлэл 7 байна. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулинд шууд зааж өгөөгүй, нууцалсан зэрэглэлээр гэж ангилсан 25 мэдээлэл байгаа юм.

2004 оны 4-р сарын 23-нд нэмэлт оруулсан Төрийн нууцын жагсаалтын хуульд “Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдох мэдээ, баримт бичгийг бүхэлд нь нууцалсан зэрэглэлээр, байнга”-ын хугацаагаар нууцлах ажээ.

Эрүүгийн хуулийн 87.1 дүгээр зүйлд төрийн нууц задруулах гэмт хэргийг зааж өгсөн байдаг. Үүнд “Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 87.2 дугаар зүйлд “Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байдаг.

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хууль нь нууцын дэглэмийг байгууллагад хамруулсан. Үүнд байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1/ Энэ хатуу заалтыг 6 дугаар зүйлээр зөөлрүүлэх оролдлого хийж нууцлахыг хориглох мэдээллийн жагсаалтыг баталсан. Үүнд тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй ажээ.

Эрүүгийн хуулийн 164-р зүйлээр санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулбал торгохоос эхлэн гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан. Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол дээд тал нь гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх юм байна.

2.4. Нэр төр сэргээх, гүтгэлэг, доромжлолтой холбоотой хууль, тогтоомж

Иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг Иргэний болон Эрүүгийн хуулиар хамгаалдаг.

2002 оны 9-р сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлээр доромжлол, гүтгэлгийг гэмт хэрэг гэж үздэг. Энэ зүйл заалтаар нэгээс зургаан сар баривчлах ял ногдуулж болно. Эрүүгийн хуулийн эдгээр зүйлд Улсын Дээд шүүхээс 2007 оны 10-р сарын 29-нд тайлбар гаргаж, нэр төр, алдар хүнд, доромжлох, гутаах зорилго, худал гүжирдлэг, олон нийт, урьд ял шийтгүүлсэн гэх мэт дээрх зүйлд дурдагдсан нэр томьёог тайлбарлажээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага энэ тайлбарыг дэвшилттэй гэж үздэггүй бөгөөд манай хуульч дараах дүгнэлт хийсэн. Үүнд: “нэр төр, алдар хүнд гэсэн ойлголтыг олон улсын жишигт тохирохгүй, гүтгэх, доромжлох хэргүүдийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хэрэг гэдэг нь тийм ч зөв тайлбар биш, ялангуяа “гүтгэх гэмт хэрэг дээр хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэж тайлбарласан нь гүтгэсэн

гэж үзэж байгаа мэдээлэл үнэн бодит байдалд нийцэхгүй, худлаа мэдээлэл юм гэдэг нь тогтоогдвол шууд л гэмт хэрэг үйлдсэн байна гэж ойлгохоор болсон байна” гэж үзэж байгаа юм.

2002 оны Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлээр иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалсан байна.

Эрүүгийн хуулиар сэтгүүлчдийг шийтгэж болзошгүй зарим заалтыг энд дурдав. Эрүүгийн хуулийн 136.1-д зааснаар “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”.

Мөн хуулиар садар самууныг сурталчилсан (123-р зүйл), иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн (135-р зүйл), шашны харгис үзэл номлолыг санаатай сурталчилсан буюу тараасан бол (144.1-р зүйл), Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсан бол (257.1-р зүйл) торгохоос нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах хүртэл ял шийтгэх ажээ.

Энэ хуульд тайлбарласнаар “Төрийн албан хаагч” гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гааль, татварын албаны байцаагч, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.

2.5. Хэвлэлийн эрх чөлөө

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталсан юм. Хуулийн 2-р зүйлээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон юм. Мөн 3 дугаар зүйлээр “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан ба 4-р зүйлээр “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэжээ.

УИХ-аас 2005 оны 1-р сарын 27-нд ОНРТ-ийн тухай хууль баталсан нь хэвлэлийн эрх чөлөөг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн чухал ач холбогдол бүхий алхам байлаа. Хууль 2005 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болон төрийн мэдлийн байсан Монголын Үндэсний радио, телевизийн Хэрэг эрхлэх газар татан буугдсан билээ. Түүний оронд Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ) байгуулагдан 2006 оны хоёрдугаар сарын наймны өдөр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн алба Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, хэвлэл мэдээллийнхэн, сэтгүүлч, иргэдээр өргөн хүрээтэй хэлэлцүүлсэн ч одоогоор батлагдаагүй байна. Хуулийн шинэчилсэн хувилбарт ХМХ-ийн хараат бус

байдлыг улам баталгаажуулах, өмчлөлийг ил тод болгох, хэвлэлийн зөвлөлийн эрх зүйн үндсийг тавих зэрэг зарчмын зарим өөрчлөлт тусгагдсан байна.

2.6 Хэвлэл мэдээллийн өмчлөл

Сүүлийн жилүүдэд Монголд хэвлэл мэдээллийн өмчлөл, эзэмшил эрх чөлөө, хараат бус байдалд нь сөргөөр нөлөөлдөг тухай олон нийтийн дунд өргөн яригддаг боловч ямар нэг алхам хийгдээгүй байв. Мөн хэвлэл мэдээллийн төвлөрлийн үйл явц гүнзгийрэх төлөвтэй байна. Шударга өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн зүйл заалт хэвлэл мэдээлэлд хамаарах боловч одоогоор тухайн хуулийг ашиглаж буй тохиолдол бараг байхгүй.

Харин дээр дурдсан “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх” заалт анх удаа тусгагджээ.

Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын “Эзэмшлийн ил тод байдал” 4-р бүлэгт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, удирдлагын талаар мэдээллийг жил бүр Зохицуулах хороонд мэдээлж байх үүргийг радио, телевизийн сувгуудад үүрэг болгосон байна. Тухайлбал:

- 4.1.1. Эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь хэмжээ /гадаад улсын хөрөнгө оруулалттай бол аль улсынх болохыг тодорхой заана/;
- 4.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас;
- 4.1.3. Хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын иргэншил

Энэ нөхцөл шаардлагад зааснаар эзэмшлийн ил тод байдлын мэдээллийг Зохицуулах хороо олон нийтэд мэдээлнэ.

2.7 Сэтгүүлчийн нууц эх сурвалж

Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай хууль Монголд байхгүй. 2005 оны 3-р сарын 11-ний өдөр хуралдсан МСНЭ-ийн 2-р их хурлаар баталсан “Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим”-аар үүнийг хүлээн зөвшөөрсөн боловч амьдралд хэрэгждэггүй.

Дөрөв. Хүний итгэлийг хүлээж олсон мэдээллийнхээ эх сурвалжийг ямар ч тохиолдолд чанад нууцална.

“Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим”-аас

2.8 Өөрийн зохицуулалт

2011 оны 3-р сарын 1-нээс мөрдөж эхэлсэн Харилцаа холбооны зохицуулах хорооны “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-д “Телевиз, радио, кабелийн суваг нь дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн нэгдсэн дүрэм, түүнийг хэрэгжүүлэх ёс зүйн хороотой байх”-ыг үүрэг болгож Зохицуулах хороо үйл ажиллагаагаа тогтмолжуулахад нь дэмжлэг үзүүлнэ гэж заасан байна.

х х х

Монголын сэтгүүлчид өнөө хэр төрийн байгууллага, албан тушаалтан, албан хаагчдаас мэдээлэл олж авч чадахгүй, төрийн байгууллагын бичиг баримтыг олж үзэх боломжгүй байгаа нь төрийн байгууллагын олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой ардчилсан зарчим алдагдаж, иргэдийн үнэн мэдээлэл олж авах эрх хөсөрдөхөд хүргэж байна. Энгийн мэдээлэл олж авах төдийд эрх нь зөрчигдөж буй сэтгүүлчид далд нуугдмал буй мэдээлэл, баримт мэдээг эрэн сурвалжилж олон түмэнд мэдээлэхэд туйлын хүндрэлтэй байгааг илтгэж байгаа юм.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл нийтэд ил тод бус байгаа нь олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжих бус, харин тэдгээрийн далд эздийн үзэл бодол, нэг талыг барьж туйлширсан мэдээллээ олон түмэнд тулган нийгмийг төөрөгдүүлэн будилахад хүргэж байна. Монголын олон нийт хэн нь үнэн ярьж байгааг ойлгохоо байж, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд итгэл алдрах нь нийгмийн шударга ёсыг уландаа гишгиж буй хэрэг юм.

Сэтгүүлчид янз бүрийн дарамт шахалт дор эх сурвалжаа илчлэх нь мэдээлэгчдийн аюулгүй байдалд ноцтой хор учруулах төдийгүй хэвлэл мэдээлэл ард иргэдийн өмнө хүлээсэн хяналтын үүргээ хөсөрдүүлэхэд хүргэнэ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдол, үнэ цэнэ алга болбол нийгэм хэзээ ч цэвэршиж, ариусахгүй.

Үнэнийг хэлэх гэсэн, хэлснийх нь төлөө сэтгүүлчдийг дайрч давшлах, далайлган сүрдүүлэх, айлган заналхийлэх, өмч хөрөнгө, бие эрхтэнд халдах нь хэрхэвч байж болохгүй ноцтой үйлдэл, гэмт хэрэг юм. Монголын цагдаа, шүүх буруутныг илрүүлэн үнэн мөнгийг тогтоож, хариуцлага хүлээлгэх үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй байгаа нь харамсалтай.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаарах хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлаас харахад ялагдсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн тоо нэмэгдэж байгаа нь шүүх олон нийтийн бодит эрх ашгийг бус нэхэмжлэгчийн эрх ашгийг дээдлэх үүднээс асуудалд хандан шийдвэр гаргаж байна гэж үзэж байна.

Сэтгүүлчийг шүүмжлэлт нийтлэл бичсэнийх нь төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал буурахгүй харин ч нэмэгдэж буй нь эрүүл саруул нийгэм төлөвшихөд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон нийтийн “хоточ нохой” байх үүргээ биелүүлэхэд нь ноцтой саад тотгор учруулж, ард түмний үнэнийг олж мэдэх эрхийг хөсөрдүүлж байна.

НҮБ-аас 2000 оны 12-р сарын 1-нд гаргасан Тунхаглалд “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, санаа бодлын асуудал дэлхийн олон оронд хямралт байдалд ороод байна. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний явцад нь сэтгүүлчид болон бусад хүмүүсийг дайран давшлах, мөн цагдан хянах, гүтгэлэг, доромжлолын хатуу хуулиар хохироох зэрэг хоёр

хэлбэрийн түгшүүрээр илэрч байна” хэмээн онцлон дурьдсан юм. Уг тунхаглалд “Гишүүн орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлах байдлыг хангахын тулд гүтгэлэгийн эсрэг хуулиа нягталж, үүнийгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэхийг” сануулсан байдаг. Энэ уриалгыг хүлээн зөвшөөрч олон орон Эрүүгийн хуулиас гүтгэлэг, доромжлолтой холбоотой заалтыг хасч, зарим орон гүтгэлгийн хэргээр хорих ялаас татгалзаад байна.

Монгол улс НҮБ-ын гишүүн орны хувьд шийдвэртэй алхам хийж, гүтгэлэг, доромжлолтой холбоотой заалтаа Эрүүгийн хуулиас хасч, НҮБ, дэлхийн олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ сахин биелүүлнэ хэмээн “Глоб Интернэшнл” ТББ итгэж байна.